

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ 6 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2018 оны дөрөвдүгээр сарын 25-ны өдрийн 14 цаг 40 минутад эхэлж, 15 цаг 38 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 58 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	<p>Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай</p> <p>-Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний ажлын байранд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай</p> <p>-Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай</p> <p>-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Сайнцагаан сум хариуцсан газрын даамлын албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 173 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Норовын Гэрэлмааг, Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтний албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Мэндбаярын Алтанчимэгийг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Сайнцагаан сумын газрын даамлын албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 33 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Баатарын Мөнх-Эрдэнийг тус тус нэр дэвшүүлж, тэдний нэр дэвшүүлсэн шийдвэр, шалгалтын материалыг холбогдох байгууллагын удирдлагад хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА